



**МОНГОЛЫН
ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ**
Mongol Securities Exchange



2018



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар-14191, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бээжингийн гудамж, GB Plaza, 703 тоот. Вэб: www.msx.mn. И-мэйл: info@msx.mn

Утас: (+976) 7000-0501, (+976) 7000-0502, (+976) 7011-3722

Компанийн тухай

Монголын Үнэт Цаасны Бирж

2015 оны 05 дугаар сард “Дилерүүдийн арилжааны төв” ХХК нэртэйгээр үүсгэн байгуулагдаж, 2015 оны 07 дугаар сард Санхүүгийн зохицуулах хорооны 312 тоот тогтоолоор “Үнэт цаасны арилжааны үйл ажиллагаа эрхлэх, Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэх” №340/01 тоот тусгай зөвшөөрөл авч, албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

2015 онд Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр компанийн оноосон нэрийг “Монголын үнэт цаасны бирж” ХХК болгон өөрчилснөөс гадна 2017 онд компанийн хэлбэрийг өөрчилж, хаалттай хувьцаат компани болгох шийдвэр гаргасан.

Компани үүсгэн байгуулагдсан цагаас хойш биржийн үйл ажиллагааг эхлүүлэх техникийн болон хууль эрхзүйн зохицуулалт, боловсон хүчин бэлтгэх, оролцогчдыг сургах гэх мэт бэлтгэл ажлуудыг хийснээс гадна үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм журмуудыг боловсруулж, СЗХ-оор батламжлуулсан. Улмаар үнэт цаас гаргагч анхны компаниа бүртгэж, биржийн арилжааг 2017 оны 4 дүгээр улиралд амжилттай эхлүүлсэн болно.

Үндсэн үйл ажиллагаа

Бүртгэл

Энэ онд анх удаа компанийн бонд бирж дээр бүртгэгдсэн. “Минж Проперти” ХХК-ийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэн, Бирж дээр бүртгэлтэй үнэт цаасны төрөл нэмэгдсэн. Түүнчлэн Бирж дээр бүртгүүлэх хүсэлт гаргасан компаниудтай танилцаж, тэдгээрийн өргөдлийг шийдвэрлэх, бичиг баримтад холбогдох өөрчлөлт оруулах, зөвлөгөө өгөх шатанд явж байна.

Биржийн бүртгэлийн шаардлагын дагуу бирж дээр бүртгэгдсэн компаниуд нийцүүлэгчээр дамжуулан зах зээлд тогтмол мэдээ гаргадаг нь бидний давуу талын нэг юм. Компаниудын талаарх мэдээллийг www.market.msx.mn цахим хуудаснаас авах боломжтой.

Биржийн бүртгэлийн үйл ажиллагааны нэг онцлог нь бүртгүүлэх хүсэлт ирүүлсэн компанийг бүртгэх эсэх тухай шийдвэрийг Биржээс хараат бус Бүртгэлийн хороо хэлэлцэн гаргадаг процесс юм. Бүртгэлийн хороо 2018 онд нэг компанийн бондыг бүртгэх шийдвэр гаргаж, “Минж Проперти” ХХК “Парк Таун Бонд”-ыг олон нийтэд санал болгон нийт 1 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлжээ.

Арилжаа

АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛ


СЗХ-ны 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 340, Биржийн Бүртгэлийн хорооны 2018 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 18/03 тоот тогтоолуудыг үндэслэн Минж проперти хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Парк Таун бондын анхдагч зах зээлийн арилжааг 2018 оны 12 дугаар сарын 07-11 өдрүүдэд зохион байгуулсан.

Анхдагч зах зээлийн арилжаагаар дотоод, гадаадын иргэд, аж ахуй нэгж, брокер, дилерүүдээс нийт 1 тэрбум 180 сая төгрөгийн захиалга ирүүлсэн бөгөөд "Минж Проперти" ХХК нийт 1 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлж, бондын анхдагч зах зээлийн арилжааны захиалга компанийн санал болгосон дүнгээс 18 хувиар давж ирсэн.

ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛ

2018 оны байдлаар нийт 248 өдрийн арилжаа явагдаж, 14,550,100 ширхэг хувьцааг 704,244,340 төгрөгөөр арилжсан байна. Үүнээс энгийн арилжаагаар 6,589,900 ширхэг хувьцаа 292,136,340 төгрөгөөр, багцын арилжаагаар 7,960,000 хувьцаа 412,108,000 төгрөгөөр тус тус арилжигдсан. Тайлант хугацаанд Анд-Энерги ХК-ийн AND хувьцааны дээд ханш 56 төгрөг, доод ханш 37 төгрөг, дундаж үнэ 44.31 төгрөг, хаалтын ханш 40 төгрөг байна. Парк Таун ХХК-ийн РТВ бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар дундаж үнэ нь 10,000 төгрөгөөр 6600 ширхэг бондыг 66,000,000 төгрөгөөр арилжсан байна.

График 1. Хувьцааны арилжааны дүн, арилжигдсан хэмжээ (сая төгрөгөөр, мянган ширхэгээр)



Арилжаанд Бумбат-Алтай, Батс, Зэргэд, Дэлгэрхангай секюритиз, Булган брокер, Монсек, Голомт капитал, Гаули, Монгол хувьцаа үнэт цаасны компаниуд оролцсоноос хамгийн өндөр үнийн дүн бүхий гүйлгээг Дэлгэрхангай секюритиз, Бумбат Алтай үнэт цаасны компаниуд гүйцэтгэлээ.

Хоёрдогч зах зээлийн арилжаанд харилцагч шууд оролцох зориулалт бүхий windows, ios, android үйлдлийн систем дээр ажиллах Харилцагчийн онлайн захиалгын систем буюу (OMS order management system) веб программыг 2018 оны 04 сарын 09-ий өдөр амжилттай нэвтрүүлсэн.

Түүнчлэн 2018 оны 04 сараас арилжааны нээлт болон хаалтын үеүдэд олон улсад ашиглагддаг үнээр удирдуулсан, захиалгаар удирдуулсан арилжааны хэлбэрүүдийг нэвтрүүлж арилжааг зохион байгуулж байна.

АРИЛЖААНЫ МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

СЗХ-ны 2018 оны 04 сарын 04-ний 142 дугаар тогтоолоор баталсан "Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам"-ын 2 дугаар бүлгийн 2.1 дэх заалтын дагуу 2018 оны 1 дүгээр сараас 6 дугаар сарын арилжааны мэдээлэл болон долоо хоног бүрийн арилжааны мэдээллийг холбогдох маягтаар бэлтгэн СЗХ-нд хүргүүлж байна. Үүнээс сар бүр СЗХ-нд арилжааны статистик мэдээлэл, үнэт цаасны өсөлт бууралт, зах зээлийн үнэлгээний мэдээлэл илгээдэг байсан бол шинээр сар бүр арилжааны шимтгэл, үнэт цаас гаргагчтай холбоотой ногдол ашиг, ХЭХ, шийдвэртэй мэдээлэл, түүнчлэн долоо хоног бүрийн арилжааны тайлан, гишүүдийн гүйлгээ, ирц, багцын арилжааны мэдээний хамт тогтмол хүргүүлж байна.

Арилжааны бодит цагийн болон арилжааны дараах өдөр тутмын мэдээллийг market.msx.mn веб хаягаар, арилжааны өдрийн болон долоо хоногийн мэдээг өдөр тутмын Өдрийн сонин хэвлэлээр дамжуулан олон нийтэд танин мэдэхгүйн мэдээллийн хамт тогтмол хүргэж байна. Мөн www.marketinfo.mn сайттай гэрээ байгуулан арилжааны мэдээлэл бодит цагийн горимд, мөн олон нийтэд санхүүгийн боловсрол олгох үүднээс долоо хоног тутамд инфографик хүргүүлж байна.


АРИЛЖААНЫ ХЯНАЛТ

"Монголын үнэт цаасны биржийн хяналтын журам", "Дотоод мэдээлэл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын дагуу үнэт цаасны мэдээллийн сан бүрдүүлэн, арилжаанд хяналт тавьж ажилладаг. Үнэт цаасны арилжааг онлайн хянах зориулалт бүхий 1 терминалыг СЗХ-ны Үнэт цаасны газарт байршуулан бодит цагийн горимоор хяналтыг хэрэгжүүлж байна.

Төлбөр тооцоо

Биржийн “Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын алба” нь 2018 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр “Нэрэн клиринг” ХХК-тай, 2018 оны 12 дугаар сарын 02-ны өдөр “Харз трейд” ХХК-тай тус тус “Төв клирингийн гишүүнчлэлийн гэрээ”-г шинэчлэн байгууллаа. Түүнчлэн клирингийн гишүүн “Харз трейд” ХХК нь “Монгол хувьцаа ХХК” үнэт цаасны компанитай “Клирингийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г мөн байгуулсан. Биржийн Тооцооны төвөөс өгсөн зөвшөөрлийн дагуу 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1,540,388,680 төгрөгийн төлбөр тооцоо гүйцэтгэсэн байна. Үүнээс “Нэрэн клиринг” ХХК 721,167,940 төгрөгийн, “Харз трейд ББСБ” ХХК 819,220,740 төгрөгийн төлбөр гүйцэтгэжээ.

График 2. Төлбөр гүйцэтгэсэн хэлцлийн дүн (сая төгрөгөөр, сараар)



2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2,022 хэлцэл хийгдсэнээс “Анд Энерги ХХК” – ийн 10,177,600 ширхэг үнэт цаасны төлбөр 449,067,580 төгрөгийг Т+3 хугацаанд төлөх 651 нээлттэй позиц үүсгэж, позицоо хугацаанд нь бүрэн хаасан байна. Мөн гишүүн компаниуд тооцооны гишүүдтэй төгрөгийн репо хэлцэл хийжээ.

Эрсдэлийн удирдлага

Биржийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа дэнчин ашиглан захиалга өгөх, төлбөрийг T+3 хүртэл хугацаанд төлөх, short sell буюу хувьцаа зээлээр худалдахтай холбоотой эрсдэлүүдийг удирдах замаар эхэлсэн бол 2018 оны эцсийн байдлаар тодорхой нэмэлт ажлууд хийгдэв. Мөн алба журамдаа эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг нарийн тусгаж өгсөн бөгөөд эрсдэлийн сангийн журам T+2 зарчимд хамаарах эрсдэлийн үзүүлэлтүүдийг дахин шинэчлэн тооцож үйл ажиллагаандаа мөрдөж байна.

ТӨЛБӨРИЙН ЭРСДЭЛ

Харилцагч үнэт цаасны төлбөрийг урьдчилж төлөхгүйгээр хэлцэл биелснээс хойш 2 хоногийн дотор төлөх тохиолдолд урьдчилж байршуулах бэлэн мөнгөний хэмжээ 25 хувь байдаг. Үүнийг дэнчин гэх бөгөөд дэнчин нь позиц нээснээс хойш 2 хоногийн хугацаанд төлбөрийн эрсдэлд учрах хохирлыг бага байлгах зорилгоор урьдчилж байршуулсан бэлэн мөнгө юм. Дэнчингийн хэмжээ (25%) 2018 онд эрсдэлийг бууруулах эсхүл хаах хэмжээнд хангалттай байсан эсэхийг дараах графикаас харж болно.

График 3. Ханшийн өөрчлөлт



Графикаас харахад 1 болон 2 өдрийн дотор ханш 25%-аас илүүтэй өөрчлөгдөөгүй тул 25% нь төлбөрийн одоогийн мөрдөгдөж буй дэнчингийн хувь нь эрсдэлийг хаах боломжит хэмжээнд байгааг илтгэж байна. Тус хувийг бууруулж хөрөнгө оруулагчдын урьдчилан байршуулах мөнгийг багасгах боломжтой хэдий ч мэдээж энэ нь нөгөө талдаа төлбөрийн эрсдэлийг нэмэгдүүлэх сул талтай.

ЭРСДЭЛИЙН САН

Хэлцэл баталгаажуулалт хийснээс үүсэх төвлөрсөн эрсдэлийг удирдах, хохирлыг барагдуулах зорилготой эрсдэлийн санг байгуулах ажлын судалгаа хийгдсэн бөгөөд брокерын хүчин чадал, мөн хэлцлийн биелэлтэд төвлөрч байгаа эрсдэлд харгалзах эрсдэлийн сангийн зохих хэмжээг тодорхойлох эрсдэлийн сангийн журмыг 2018 онд баталсан.

ҮНЭТ ЦААСНЫ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

Хөрөнгө оруулагчдад репо хэлцэл болон short sell-ийг боломжтой болгохын тулд үнэт цаасны зээл хэмээх ойлголтыг нэвтрүүлэх шаардлага гарсан. Тус шаардлагын хүрээнд хийгдсэн ажлууд бол зээлийн сан байгуулах, зээлийн сангийн мастер болон дагалдах гэрээг боловсруулах, үнэт цаасны жишиг үнэ тогтоох болон барьцаа хөрөнгийг үнэлэхэд ашиглагдах хорогдуулах хувийг тооцох аргачлалыг журамд тусгасан. Дурдсан аргачлалуудыг олон улсын жишгээр гүйцэтгэхээр тусгасан.

Зах зээлийн зохицуулалт, дүрэм журам

Биржийн үйл ажиллагааны чухал хэсэг нь эрх зүйн зохицуулалт байдаг. Монгол улсын хууль, эрх зүйн орчинд нийцсэн байхаас гадна зах зээлд оролцогчдыг дэмжих, зохицуулалттай зах зээлд оролцох боломжийг хүн бүрт хүртээмжтэй хялбар болгох, өөрийн гишүүдийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх нь бидний үндсэн зорилгын нэг. Энэхүү зорилгынхоо хүрээнд бид зах зээлийн зохицуулалтаа үргэлж шинэчлэн сайжруулж байдаг бөгөөд 2018 онд үндсэн үйл ажиллагаатай холбоотой дараах журмуудыг шинээр болон шинэчлэн найруулж, нэмэлт өөрчлөлт оруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Үүнд:

- Монголын үнэт цаасны биржийн Бүртгэлийн журамд орсон нэмэлт, өөрчлөлт болон Арилжааны журам, Гишүүнчлэлийн журам, Тооцооны үйл ажиллагааны журмуудын шинэчилсэн найруулгыг ТУЗ-ийн хурлаар баталж, СЗХ-оор батламжлуулсан.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн найруулж баталсан ба үүний дараа өөрчлөлт оруулсан.
- Тайлант хугацаанд Гүйцэтгэх захирлын тушаалаар албадын журам болон тэдгээрийн үйл ажиллагааны журмыг шинээр болон шинэчлэн баталсан. Үүнд: Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны журам, Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын албаны дотоод журам,

Эрсдэлийн сангийн журам, Бүртгэлийн үйл ажиллагааны журмыг тус тус шинээр баталсан ба Арилжаа мэдээллийн албаны журам, Арилжаа зохион байгуулах журмыг тус тус шинэчлэн найруулж баталсан. Мөн Бүртгэлийн гэрээ болон Бүртгэлийн гэрээний ерөнхий нөхцөлийг шинэчлэн найруулсан.

Гишүүнчлэл

"Монголын үнэт цаасны бирж" ХК нь арилжааны 10 гишүүнтэй бөгөөд тайлант хугацаанд гишүүнээр элсэх 2 хүсэлтийг хүлээн авч МҮЦБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 05 өдрийн 18/17 дугаар тогтоолоор "Монгол хувьцаа ҮЦК" ХХК-г Биржийн гишүүнээр элсүүлэхээр шийдвэрлэсэн.

Гишүүд болон харилцагчдад Онлайн захиалгын систем нэвтрүүлсэнтэй холбогдуулан шат дараалсан сургалтыг зохион байгуулсан бөгөөд МҮЦБ-ийн арилжаа болон гишүүнчлэлийн журмын төсөлд гишүүдээс санал авах зорилгоор тус танилцуулга хийсэн болно.

Гишүүн ҮЦК-ийн үйл ажиллагаатай танилцах ажлыг 2018 оны 5 сарын 21-25 өдрүүдэд зохион байгуулж гишүүдийн санал, хүсэлтийг хүлээн авсан.

"Монголын Үнэт Цаасны Бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн 2018 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 12 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан "Гишүүнчлэлийн журам"-ыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2018 оны 8 сарын 2-ны өдрийн 456 тоот тушаалаар батламжилсантай холбогдуулан Гишүүн ҮЦК бүртэй ганцаарчлан 2018 оны 11 сарын 14-16 өдрийн хооронд шинээр батлагдсан журмуудын танилцуулга хийж Гишүүнчлэлийн гэрээг шинэчлэн байгуулаад байна.

ЗАХ ЗЭЭЛ ҮҮСГЭГЧ

Арилжааны идэвхийг дэмжих, арилжаалж буй үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор "Монголын үнэт цаасны биржийн арилжааны журам"-ын 6 дугаар бүлэгт заасны дагуу Дэлгэрхангай секюритис ҮЦК-тай Зах зээл үүсгэх гэрээг 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдөр шинэчлэн байгуулан ажилласан. Зах зээл үүсгэх гэрээний хавсралт Тусгай гэрээнд заасан хугацаанд Зах зээл үүсгэгч нь нийт 57 удаагийн арилжаанд оролцох байснаас 46 удаад нь оролцон гэрээний нөхцлийг хангалттай биелүүлсэн.

Мөн 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн Бумбат Алтай ҮЦК-тай Зах зээл үүсгэх гэрээг байгуулан ажиллаж байна.

Маркетинг, олон нийттэй харилцах

- МУИС, Хүмүүнлэг, СЭЗДС, ШУТИС, ХААИС-д Биржийн үйл ажиллагааг танилцуулах, демо арилжаанд оролцох талаар уулзалт зохион байгуулав.
- МҮХАҮТ-аас зохион байгуулсан компаниудын захирлуудад зориулсан сургалтанд оролцов.
- НҮБ-ийн тогтвортой хөгжлийг дэмжигч биржүүдийн санаачлага, F1X-д нэгдэн оров.
- “Минж проперти” ХХК-ийн Парк таун бондыг олон нийтэд танилцуулах, анхдагч зах зээлийн арилжааны нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулав.
- Компанийн цахим хуудас, сошиал медиаг хариуцан холбогдох мэдээллийг оруулан ажиллаж байна.
- СЗХ-оос зохион байгуулсан холбогдох журамд өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж ажиллав. Үүнд: Бүртгэлийн журам, Давхар бүртгэлтэй холбоотой журам, Бүртгэлтэй компаниудын мэдээлэлтэй холбоотой журам.

Санхүү

Санхүүгийн тайлангууд

Энэ хэсэгт агуулагдаж буй санхүүгийн тайлангууд нь зөвхөн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд бий болсон санхүүгийн үр дүнгүүдийг харуулж байгаа бөгөөд аудитлагдаагүй, урьдчилсан гүйцэтгэлээрх дүн болохыг анхаарна уу.

2018 онд компани хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гарган санхүүжилт татсан бөгөөд өмнөх онд хуримтлагдсан зарим өр төлбөр болон үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд нэмэлт хөрөнгө оруулалтыг зарцуулсан. Мөн тайлант оноос эхлэн биржийн төлбөр тооцооны нэгжийн санхүүгийн тайланг компанийн санхүүгийн тайлангаас тусад нь толилуулж тайлагнаж эхэлсэн. Доорх тайлангууд нь тооцооны нэгжийн санхүүгийн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг агуулаагүй, зөвхөн Монголын үнэт цаасны бирж ХК-ийн өөрийн санхүүгийн үр дүн, бодит байдлыг харуулсан болно.

Жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг аудитын тайлан гарсны дараа нэмэлт хавсралтаар танилцуулна.

Санхүүгийн байдлын тайлан /сая төгрөгөөр/

	2017 он	2018 он
ХӨРӨНГӨ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3.82	3.38
Дансны авлага	6.19	10.11
Бусад авлага	87.74	151.34
Бараа материал	4.95	5.28
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	60.58	220.69
Эргэлтийн хөрөнгийн дүн	163.28	390.80
Үндсэн хөрөнгө	149.60	119.82
Биет бус хөрөнгө	4,418.39	4,270.28
Бусад эргэлтийн бус хөрөнгө	230.53	229.95
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,798.51	4,620.05
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,961.80	5,010.85

ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Дансны өглөг	0.05	0.71
Цалингийн өглөг	100.19	63.16
Татварын өр	9.15	3.78
НДШ-ийн өглөг	-	9.50
Богино хугацаат зээл	160.00	125.82
Хүүний өглөг	-	5.35
Бусад богино хугацаат өр төлбөр	335.34	382.67
Клирингийн тооцоо	-	11.20
Богино хугацаат өр төлбөрийн дүн	604.72	602.19
Урт хугацаат зээл	40.00	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	40.00	-
Өр төлбөрийн нийт дүн	644.72	602.19
Өмч: Хувийн	4,187.00	4,380.50
Нэмж төлөгдсөн капитал	877.00	1,407.50
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	231.00	231.00
Эздийн өмчийн бусад хэсэг	50.00	-
Хуримтлагдсан ашиг	(1,027.93)	(1,610.35)
Эздийн өмчийн дүн	4,317.07	4,408.65
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,961.80	5,010.85

Орлогын дэлгэрэнгүй тайлан /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2017 он	2018 он
Борлуулалтын орлого (цэвэр)	0.66	6.63
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг (алдагдал)	0.66	6.63
Хүүний орлого	5.51	11.76
Бусад орлого	-	19.90
Ерөнхий ба удирдлагын зардал	334.70	570.66
Санхүүгийн зардал	40.93	47.25
Бусад зардал	0.72	0.75
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	2.82	(0.87)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(367.36)	(581.24)
Орлогын татварын зардал	0.55	1.18
Татварын дараах ашиг (алдагдал)	(367.91)	(582.42)

Өмчийн өөрчлөлтийн тайлан /сая төгрөгөөр/

	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017.01.01-ний үлдэгдэл	3,670.50	360.50	231.00	70.00	(660.02)	3,671.98
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(367.91)	(367.91)
Өмчид гарсан өөрчлөлт	516.50	616.50	-	(20.00)	-	1,013.00

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН - 2018

Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
2017.12.31-ний үлдэгдэл	4,187.00	877.00	231.00	50.00	(1,027.93)	4,317.07
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(582.42)	(582.42)
Өмчид гарсан өөрчлөлт	193.50	530.50	-	(50.00)	-	674.00
2018.12.31-ний үлдэгдэл	4,380.50	1,407.50	231.00	-	(1,610.35)	4,408.65

Мөнгөн гүйлгээний тайлан /сая төгрөгөөр/

	2017 он	2018 он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	1.16	4.25
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1.16	4.25
Бусад мөнгөн орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	363.24	472.48
Ажиллагчдад төлсөн	72.63	124.61
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	54.57	26.13
Бараа материал худалдан авахад төлсөн	14.53	5.38
Ашиглалтын зардалд төлсөн	86.61	100.51
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.39	1.47
Хүүний төлбөрт төлсөн	42.98	41.90
Татварын байгууллагад төлсөн	15.53	16.79
Даатгалын байгууллагад төлсөн		0.1
Бусад мөнгөн зарлага	75.99	155.60
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(362.07)	(468.23)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	4.56	240.84
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	236.14
Хүлээн авсан хүүний орлого	4.56	4.70
Мөнгөн зарлагын дүн (-)	520.38	374.15
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	126.52	15.60
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8.39	43.27
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	385.47	315.28
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(515.82)	(133.31)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	962.90	752.95
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	275.90	78.95
Хувьцаа болон өмчийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	687.00	674.00
Мөнгөн зарлагын дүн (-)	95.50	153.13
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	95.50	153.13
Төлсөн ногдол ашиг	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	867.40	599.82
Валютын ханшийн зөрүү	(1.99)	1.29
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(12.48)	(0.44)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16.30	3.82
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3.82	3.38


Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн тайлбар

Тайлант онд Монголын үнэт цаасны бирж ХК хаалттай хүрээнд хөрөнгө оруулалт босгож, 674.0 сая төгрөгийг татан төвлөрүүлж, 19,350,000 ширхэг хувьцааг нэмж гаргасан. Нэмэлт хувьцааг холбогдох дүрэм журмын дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгүүлж, компанийн дүрэмд холбогдох өөрчлөлтийг оруулсан болно. Ингэснээр биржийн гол хувьцаа эзэмшигч буюу толгой компанийн эзэмшлийн хувь 68.7% болон буурч, хөрөнгө оруулагчийн тоо 25 болж нэмэгдсэн байна.

Эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь 7.8% болж өмнөх оны үзүүлэлтээс 2 дахин өссөн. Энэ нь дансны болон бусад авлага, урьдчилж гарсан зардлын өсөлттэй холбоотой. Биржийн арилжаанд ашиглагдаж буй программ хангамжуудын хөгжүүлэлтийн хүрээнд хэд хэдэн газартай гэрээ байгуулж, MSX Client программын дизайн гаргах ажлыг гүйцэтгүүлсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор санхүүгийн байдлын тайлангийн урьдчилж гарсан зардлын дүн 70 орчим хувийн өсөлттэй гарсан.

Капиталын бүтцээр нь авч үзвэл нийт хөрөнгийн 12 хувийг өр төлбөр буюу гадны капитал бүрдүүлж байна. Тайлант хугацаанд өмнөх онд банк санхүүгийн байгууллагаас зээлсэн зээлийн төлбөр болон цалингийн өр төлбөрт нийт 111.2 сая төгрөгийг төлж барагдуулсан бөгөөд гэрээт ажлын зардлын төлөгдөөгүй дүн болон түрээсийн төлбөртэй холбоотойгоор бусад богино хугацаат өр төлбөрийн дүн 47.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

График 4. Өр төлбөр болон өөрийн хөрөнгийн харьцуулалт (сая төгрөгөөр)




2018 онд нийт 206 удаагийн арилжааг 9 гишүүн, 2 тооцооны ерөнхий гишүүний оролцоотойгоор явуулсан бөгөөд нийт Анд-Энерги ХК-ийн 14,550,000 ширхэг үнэт цаасны 704.19 сая төгрөгөөр, Минж проперти ХХК-ийн 1.0 тэрбум төгрөгийн бондын анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж,

2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлж, 6,600 ширхэг үнэт цаас арилжигдсан байна.

Тайлант онд Монголын үнэт цаасны бирж 6.6 сая төгрөгийн шимтгэлийн орлоготой ажилласан.

Компанийн ТУЗ-ийн шийдвэрээр үнэт цаасны бүртгэлийн шимтгэл, гишүүний элсэлтийн болон жилийн хураамж гэх мэт зарим орлого төвлөрүүлэх хугацааг түр хойшлуулсан, мөн IPO гаргахаар төлөвлөсөн компаниудын бэлтгэл ажлын явц удааширснаас хамааран орлогын гүйцэтгэл төсөвлөсөн хэмжээнд хүрээгүй болно.

График 5. Зардлын бүтэц (хувиар)



Зардлын хувьд өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 70 орчим хувийн өсөлттэй байна. Үйл ажиллагааны зардлын энэхүү өсөлт нь цалин хөлс, ЭМНДШ-ийн зардал болон элэгдэл, түрээсийн зардлын өсөлттэй холбоотой.


Арилжаа, тооцооны үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 1.2 тэрбум төгрөгийн анхны өртөгтэй программ хангамжийн элэгдлийн зардлыг 2018 оноос эхлэн тооцоолж эхэлснээс элэгдлийн зардлын дүн өмнөх оноос 4.5 дахин өссөн. Мөн тайлант оны хоёрдугаар улирлаас эхлэн ажилтан албан хаагчдын үндсэн цалин хөлсийг нэмэгдүүлсэн нь мэргэшсэн боловсон хүчнээ хадгалж авч үлдэх удирдлагын бодлоготой холбоотой.

Компанийн засаглал, удирдлага

Бүтэц, зохион байгуулалт

ТУЗ-ийн 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 20 тоот тогтоолоор байгууллагын бүтэц, орон тоог 5 алба, 25 хүний орон тоотой шинэчлэн баталсан. Тайлант хугацаанд 5 ажилтан шинээр томилогдож, 4 ажилтныг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн ба 2018 оны жилийн эцсийн байдлаар 16 үндсэн ажилтны бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

График 6. Компанийн засаглалын бүтэц



Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4-т “хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна” гэж заасны дагуу тайлант оны 3 дугаар сарын 28-ны өдөр Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн дүгнэлт, ТУЗ-ийн үйл ажиллагааны бүрэн эрхийн хугацаа дууссан тул бүрэлдэхүүнийг дахин болон шинээр томилох, эргэлтэд хувьцаа нэмж гаргасантай холбогдуулан компанийн дүрэмд өөрчлөлт оруулах зэрэг асуудлуудыг хэлэлцсэн бөгөөд Компанийн 2022 он хүртэлх стратеги төлөвлөгөөтэй танилцсан.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн шийдвэрийн дагуу Компанийн зарласан хувьцаанаас 10 сая ширхэг хувьцааг эргэлтэд нэмж гаргаснаар нийт эргэлтэд гаргасан энгийн хувьцааны тоо 438.05 сая ширхэг, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 4.3805 тэрбум төгрөгт хүрсэн ба шинээр 2 хувьцаа эзэмшигч нэмэгдэж нийт 24 хувьцаа эзэмшигчтэй болсон.

Төлөөлөн Удирдах Зөвлөл

Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр сонгогдсон 9 гишүүнтэй. Эдгээрээс 3 гишүүн нь хараат бус гишүүд. ТУЗ-ийн дэргэд ТУЗ-ийн гишүүдээс бүрдсэн тус тусын чиг үүрэг бүхий дэд хороод ажилладаг. Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ТУЗ-ийн үйл ажиллагааны талаар товч танилцуулбал:

- ТУЗ-ийн хурал нийт 6 удаа, хороодын хурал 3 удаа хуралдсан.
- ТУЗ-ийн хурлаар нийт 18 асуудал хэлэлцсэнээс хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн олонхийн саналаар 16 тогтоол гарган баталгаажуулсан байна. Үүнд:
- ТУЗ-ийн гишүүдийн тоо 2017 оны төгсгөлд 8 байсан бол 2018 оны төгсгөл гэхэд 9 гишүүнтэй байна. ТУЗ-өөс энгийн 1 гишүүн чөлөөлөгдөж, энгийн 2 гишүүн шинээр сонгогдсон. Үүнд:
 - 3-р сарын 28-ны өдрийн ХЭХ-аар ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан бүрэлдэхүүнээр нь чөлөөлсөн,
 - Мөн хурлаар ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүнийг сонгохдоо энгийн гишүүн Б.Түвшинг чөлөөлж, С.Цэрэн, З.Цэцэн нарыг шинээр сонгосон байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүн

Нацагдорж ЦОГТ

ТУЗ-ийн дарга

ТУЗ-д сонгогдсон огноо: 2015.05
Өмгөөллийн Цогт энд Нандин ХХН,
Ерөнхий захирал 2014 оноос,
Монголын өмгөөлөгчдийн холбоо,
Стратегийн хорооны дарга 2010-2013,
БОНАЛЕКС ХХК, Гүйцэтгэх захирал,
Ахлах хуульч, 2006-2014.

Жадамба ЭРДЭНЭБАТ

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-д сонгогдсон огноо: 2015.05
Хөдөө аж ахуйн бирж ХХК, Гүйцэтгэх
захирал 2013-2016,
МОСДАК ХХК, Гүйцэтгэх захирал 2007-
2013,
Ханын материал ХК, Санхүү эрхэлсэн
дэд захирал 2002-2004,
Ноён суудал ҮЦК, Гүйцэтгэх захирал
1996-2001.

Даваадорж ЖАРГАЛ

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-д сонгогдсон огноо: 2015.05
Дэлгэрэх хүнс ХК, Ерөнхий захирал,
Өвөрхангай хүнсний үйлдвэр,
Захирал, 1991-2015,
Өвөрхангай хүнсний үйлдвэр, Ерөнхий
инженер, 1982-1991.

Сэмжид ЦЭРЭН

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-д сонгогдсон огноо: 2018.03
2010-2017 онд "Мөнгөн сувд" ХХК,
гүйцэтгэх захирал,
2006 оноос "Мон-Чин" ХХК-ийн
Ерөнхий захирал.

Зантав ЦЭЦЭН

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-д сонгогдсон огноо: 2018.03
2003-2007 онд Эрин интернэшнл ХХК,
дэд захирал,
2007 оноос Тэлмэн групп ХХК,
Ерөнхий захирал.

Төмөрбаатар БОЛД

ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-д сонгогдсон огноо: 2015.05
Мосдак ХХК, Гүйцэтгэх захирал,
Дэлгэрхангай секюритиз ҮЦК, Дилер,
Дэд захирал, 1995-2015,
Монголын хөрөнгийн бирж, Хяналтын
албаны ажилтан, 1992-1995.

Базар АЮУШ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-д сонгогдсон огноо: 2015.05
СЗХ, Даргын зөвлөх 2010-2012,
СЗХ, Үнэт цаасны газрын орлогч
дарга, 2006-2010,
Үнэт цаасны хороо, БСХО хэлтсийн
дарга 1996-2006.

Лхагважав ГАНГЭРЭЛ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-д сонгогдсон огноо: 2015.05
NASM ХХК, Гүйцэтгэх захирал, 2009-
2016,
Могойн гол ХК, ТУЗ-ийн хараат бус
гишүүн, 2015-2016,
МИК актив-2, Мик актив-3, ТУЗ-ийн
дарга, 2014-2015,
Сангийн яам, Сайдын зөвлөх, 2012-
2012.

Баатаржав ЛХАГВАЖАВ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-д сонгогдсон огноо: 2015.05
МҮХАҮТ-ын УЗ-ийн дарга,
Ерөнхийлөгч, 2015 оноос,
МАН, Ажлын албаны зөвлөх, 2013-
2013,
Монгол Улсын Ерөнхий сайдын
зөвлөх, 2012-2012.



**МОНГОЛЫН
ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ**

Mongol Securities Exchange